

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Огноо: **2020-04-27.**

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТ  
ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕР**

**Харьцуулалт/  
гэрээний дугаар:**

**МХЕГ/202001009**

## Нэг. ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА-№МХЕГ/202001009

**Мэргэжлийн хяналтын ерөнхий газар** нь Шатахуун нийлүүлэх цахим тендерт аж ахуйн нэгж байгууллагуудыг үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. **Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 1 жил буюу 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлын борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнтэй тэнцэхүйц байна.
2. **Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 1 жил буюу 2019 онд санал болгож буй үнийн дүнтэй тэнцэхүйц, ижил төстэй бараа нийлүүлсэн байх.
3. Бүх төрлийн шатахууны жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх.

Үнийн саналыг 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 10:30 цагаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 11:00 цагт Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын **хурлын танхимд** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Засгийн газрын тохируулагч агентлаг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, 3Г-ын XII байр, 211 тоот өрөө, Утас: 263406**

Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.pcsp.gov.mn](http://www.pcsp.gov.mn)

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
  2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
  3. Тендерийн иж бүрдэл
  4. Тогтмол үнэ
  5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
  6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
  7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
  8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
  9. Хувилбарт тендер
- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна.
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
  - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. Үнийг харьцуулахдаа барааны нэгжийн үнээр үнэлнэ.
  - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг тооцсон тендерийн үнэ байна.
- Хувилбарт тендер ирүүлэхийг **“зөвшөөрөхгүй”**

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт   |
|-------------------------|--|
| ТӨӨЗ 1.1                | <p>-Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан;<br/>                     -Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хуулбар/;<br/>                     -Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <b>Бүх төрлийн шатахууны жижиглэнгийн худалдаа эрхлэх эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байх;</b></p>   |
| ТӨӨЗ 2.1                | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:<br/>                     Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, 3Г-ын XII байр;</b><br/>                     Давхар болон өрөөний дугаар: <b>Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 2 давхар, 211 тоот;</b><br/>                     Огноо: <b>2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 10:30 цаг;</b></p>   |
| ТӨӨЗ 2.1                | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:<br/>                     Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, 3Г-ын XII байр;</b><br/>                     Давхар болон өрөөний дугаар: <b>Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, 2 давхар, хурлын танхим;</b><br/>                     Огноо: <b>2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 11:00 цаг;</b></p>   |
| ТӨӨЗ 3.1                | <p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тендерийн маягтыг ТББ-т заасан МАЯГТ №:ТШМ-1-ийн дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>-Үнийн санал;</li> <li>-Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь /баталгаажуулсан байх/;</li> <li>-Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>-Татварын өргүй эсэхийг тодорхойлсон цахим тодорхойлолт</li> <li>- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт</li> <li>- Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, тендерийн баримт бичгийн маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ,</li> <li>- Шатахууныг стандартад нийцсэн эсэхийг нотолсон итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнгийн хуулбар;</li> <li>-Шатахуун үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүний сертификат, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээний хуулбар, бусад нотлох баримт;</li> <li>-Компаний салбар нэгжийн хаяг, байршлын мэдээлэл ирүүлэх;</li> <li>-Тендерийн материалд Хувь хүний болон байгууллагын нууцын тухай хуульд заасан нийтэд ил болгох хориглосон мэдээлэл байгаа бол уг мэдээллийг ялган ирүүлэх ба мэдээллийг ил болгохыг хориглосон үндэслэлээ тайлбарласан байна.</li> </ul> |
| ТӨӨЗ 6.2                | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>багцгүй</b></p>   |
| ТӨӨЗ 7.1                | <p>Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p>  |
| ТӨӨЗ 7.2                | <p>Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. Үнийг харьцуулахдаа <b>БАРААНЫ НЭГЖИЙН ҮНЭЭР</b> үнэлнэ.</p>  |

## Дөрөв: ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт: “Шатахуун” нийлүүлэх
2. Стандарт: MNS 0217:2017 Хөдөлгүүрийн түлш. Этилжүүлээгүй бензин. Техникийн шаардлага, MNS 0216:2017 Дизелийн түлш Евро. Техникийн шаардлага стандартуудыг хангасан байх;
3. Баглаа, боодол: Шатахууныг заавал захиалагчтай байгуулсан гэрээнд тусгагдсан автомашинуудад олгоно.
4. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| Нэр            | Тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа |                          |                                      |
|----------------|--------------|------------|-------------|--|---|--------------------------|--------------------------------------|
|                |              |            |             |  | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа                               | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1              | 2            | 3          | 4           | 5                                      | 6   | 7                        | 8                                    |
| А-92 шатахуун  |              | 13600      | Л           | МХЕГ –ын бүртгэлтэй автомашинууд       | 2020.05.18  | 2020.12.31               |                                      |
| ДТ-дизель түлш |              | 2430       | Л           |  |   |                          |                                      |

5. Бусад: Шатахууныг стандартын шаардлагад нийцсэн эсэхийг баталсан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг хавсаргасан байх шаардлагатай.
6. Нийлүүлэгч нь захиалагчийн жолооч бүрт шатахууны цахим карт олгох бөгөөд цахим картаар:
  - Захиалагч шатахууны гүйлгээг цахимаар хийж, тайланг харах, карт, дансны үлдэгдлийг шалгах эрхтэй байх;
  - Захиалагч жолооч бүрийн урьдчилсан төлбөрт цахим карт руу мөнгө шилжүүлж, алсын цэнэглэлт хийсэн тохиолдолд тухайн цэнэглэсэн карт 30 минутын дотор үйлчилгээ авах эрхтэй болох;
  - Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчээс тодорхой хугацаа, хэмжээгээр шатахууны зээл авах боломжтой байх;
7. Нийлүүлэгч нь төв, орон нутагт /аймаг, сумдад/ салбаруудтай байх;
8. Шатахуун цэнэглэх үйл ажиллагаа, шатахууны чанар нь газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн технологи, үйл ажиллагааны аргачлал MNS 4633:2006 стандартад нийцсэн байх;

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл          | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1                  | 2            | 3                         | 4          | 5        | 6        | 7                             | 8        |
|                    |              |                           |            |          |          |                               |          |
|                    |              |                           |            |          |          |                               |          |
| Тендерийн нийт үнэ |              |                           |            |          |          |                               |          |

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

ТЕНДЕРИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, **[тендерт оролцогчийн нэрийг оруул]**, энэхүү тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн **[бараа болон бусад үйлчилгээний нэрийг оруул]**-г **[тендерийн үнийг тоогоор болон үсгээр оруул]** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэхээр санал болгож байна.
2. Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээнд заасан барааг гэрээ байгуулснаас хойш **[моо]** хоногийн дотор нийлүүлнэ. Энэ нь техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарьт үндэслэнэ.
3. Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд дараах үнийн хөнгөлөлт **[үзүүлнэ эсхүл үзүүлэхгүй гэдгийн аль нэгийг оруулах]** **[Үнийн хөнгөлөлт үзүүлэхээр бол техникийн тодорхойлолтонд дурдсан бараа болон бусад үйлчилгээний аль хэсэг, нэр төрөлд эсхүл бүхэлд нь ямар хөнгөлөлт үзүүлэх саналтай байгаа, үнийн хөнгөлөлт тооцох аргачлалыг хэрхэн хэрэглэх талаарх саналаа оруул]** үзүүлнэ.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс **[моо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
5. Бид, энэхүү тендер шалгаруулалтаар нийлүүлэгдэх бараа, түүнийг дагалдах бусад үйлчилгээний техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон үнэлгээний хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй болохоо мэдэгдэж байна.
6. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч,<br>холбоо<br>барих<br>хаяг/утас/фа<br>кс | Гэрээний<br>үнийн дүн | Гэрээний<br>эхлэх хугацаа | Гэрээний<br>дуусах<br>хугацаа |
|--------------|---|-----------------------|---------------------------|-------------------------------|
| 1.           |   |                       |                           |                               |
| 2.           |   |                       |                           |                               |
| 3.           |   |                       |                           |                               |
| 4.           |   |                       |                           |                               |
| 5.           |   |                       |                           |                               |
| бусад.       |   |                       |                           |                               |



## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 12 сар байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
  - 1.1. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг хуулбараар ирүүлэх.
  - 1.2. Барааг жилийн туршид захиалагчаас шаардсан тоо хэмжээгээр нийлүүлнэ.
  - 1.3. Барааг захиалсанаас хойш тухай бүр нийлүүлнэ.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
  - 2.1 Энд заасан бичиг баримтыг барааг хүргэх газарт бараатай хамт захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
    - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
    - 2) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан зарлагын болон Е баримт;
3. Баталгаат засвар (ГЕН-5)
  - 3.1 Бүтээгдэхүүний чанар, үйлчилгээний тусгай шаардлага.

Барааг техникийн тодорхойлолтод шатахуун цэнэглэх үйл ажиллагаа, шатахууны чанартай холбоотой асуудлыг газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн технологи, үйл ажиллагааны аргачлал MNS 4633:2006 стандартын дагуу гүйцэтгэнэ.
4. Төлбөр (ГЕН – 7)
  - 4.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Захиалагч сар бүр барааны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup>
  - 5.1 Алданги оногдуулах хувь: *Шатахууныг хэрэгцээт хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хоног тутамд нийлүүлэх барааны үнийн дүнгийн 0,05 хувиар*
6. Нийлүүлэх тоо хэмжээ
  - 6.1 Барааг 1 жилийн туршид захиалагчид шаардлагатай хэмжээгээр /литрээр/ нийлүүлнэ.
  - 6.2 Барааг захиалагчийн картаар цэнэглэж нийлүүлнэ.
7. Гэрээний үнэ
  - 7.1 Барааг тендерт ирүүлсэн үнээр гэрээний хугацаанд нийлүүлнэ.
  - 7.2 Гэрээний хугацаанд гэрээний үнэнд өөрчлөлт орсон тохиолдолд хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.